

ЦАГДААГИЙН УДИРДЛАГА, СТРАТЕГИ

ХҮҮХЭД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭСРЭГ ГЭМТ ЯВЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Г.Болор-Эрдэнэ

ДХИС-ийн Удирдлагын академийн Цагдаагийн удирдлага, стратегийн тэнхимийн ахлах багш, доктор (PhD), цагдаагийн хошууч

Товч агуулга: Энэхүү өгүүлэлээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг оновчтой зохион байгуулах талаар үнэлэлт дүгнэлт өгч шалтгаан нөхцлийг тайлбарласан.

Abstract: In this article, the determine the profile and socio-psychological characteristics of persons who have committed domestic violence, gave an assessment and explained the reasons for the optimal organization of measures to prevent this type of crime.

Түлхүүр үгс: Гэр бүл, урьдчилан сэргийлэх, сэтгэл зүй, гэмт хэрэг

Keywords: Family, prevention, psychology, crime

Оршил

Монгол Улсын хэмжээнд 2017 оноос 2022 оны хооронд гэр бүлийн хүчирхийллийн улмаас 7577 гэмт хэрэг үйлдэгдсэн бөгөөд уг гэмт хэргийн улмаас 6862 хүүхэд, эмэгтэйчүүд гэмт хэргийн шууд болон дам хохирогч болсон байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн 53.6 хувь нь Улаанбаатар хотод, 46.2 хувь нь орон нутагт үйлдэгдсэнээс үзэхэд хот болон хөдөө, орон нутагт бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн тохиолдол томоохон ялгаа үгүй байна. 2017 онд НҮБ-ын Хүн амын сангаас гүйцэтгэсэн судалгаагаар 2017 он хүртэлх хугацаанд Монгол Улсад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн

тохиолдлын 84 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн байна¹.


Энэхүү судалгааны хүрээнд Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаар цаашид иргэд ямар төсөөлөлтэй байгаа, хохирогч болсон иргэдийн хууль сахиулах байгууллагад итгэх итгэл, хамтарсан багийн үйл ажиллагаа энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээнд үнэлэлт өгөх зорилгоор 200 гаруй иргэдийг судалгаанд хамруулсан.

Нэг. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаарх Улаанбаатар хотод оршин сууж байгаа иргэдээс авсан судалгаа

¹ НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа (Улаанбаатар: НҮБ-ын


Хүн амын сан болон Үндэсний статистикийн хороо), 2018, 41 дэх тал.

Зураг 1. Монгол улсад цаашид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаарх төсөөлөл



Улаанбаатар хотод оршин сууж амьдарч байгаа 200 иргэдээс “Монгол улсад цаашид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаарх төсөөлөл” ямар байгаа талаар асуусан асуулгад нийт оролцогч нарын 2.8 хувь их энэ гэмт хэргийн гаралт ихээр буурна, 27.8 хувь нь буурна, 30.6 хувь нь ямар нэгэн төсөөлөлгүй байна гэсэн бол 25 хувь нь өснө, 13.9 хувь нь ихээр өснө гэж хариулсан байна.


Зураг 2. Таны ойр дотны хүмүүс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болж байгаа байдал



Таны ойр дотны хүмүүс гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болж байгаа эсэх талаарх асуулгад судалгаанд хамрагдсан иргэдийн 57.1 хувь нь

ойр дотны хүн нь гэмт гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болоогүй талаар хариулсан бол 42.9 хувь нь ойр дотны гэр бүлийн гишүүд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болж байгаа талаар хариулсан байна.


Зураг 3. Хохирогч болсон таны ойр дотны хүмүүс цагдаагийн байгууллагад мэдэгдсэн байдал



Хохирогч болсон таны ойр дотны хүмүүс цагдаагийн байгууллагад энэ талаараа мэдэгдсэн үү? гэсэн асуулгад 64.7 хувь нь цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй, 35.3 хувь нь мэдэгдсэн гэж хариулсан байна. Дээрх судалгааны асуулгын үр дүн Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч нарын хууль сахиулах

байгууллагад итгэх илтгэл сул байгааг харж болохоор байна.

Зураг 4. Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнд таны сэтгэл ханамжтай байдал



Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, хамтарсан багийн үйл ажиллагааны үр дүнд та сэтгэл хангалуун байна вэ гэсэн асуулгад судалгаанд хамрагдсан иргэдийн 75 хувь нь сэтгэл хангуун бус байгаа талаараа хариулсан бол 25 хувь нь хамтарсан багийн үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгаа талаараа хариулсан байна.

Зураг 5. Таны бодлоор, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн хэдэн хувь нь цагдаад хандаж байгаа эсэх

Таны бодлоор, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн хэдэн хувь нь цагдаад хандаж байгаа вэ гэсэн асуулгад судалгаанд хамрагдсан иргэдийн 60 хувь нь хохирсон хохирогч нарын 50 хувь нь, 14.3 хувь нь хохирсон иргэдийн 30 хувь нь, 11.4 хувь нь хохирсон хохирогч нарын 20 хувь нь, 8.6 хувь

нь хохирсон иргэд 100 хувь цагдаагийн байгууллагад хандаж байгаа гэж хариулсан, 5.7 хувь нь хохирсон иргэдийн 80 хувь нь тус тус цагдаагийн байгууллагад хандаж байна гэж үзсэн байна.

Зураг 6. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход хамгийн түрүүнд хэн хамааралтай вэ?



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход хамгийн түрүүнд хэнээс хамаарна гэж бодож байна гэсэн асуулагад 11.1 хувь нь УИХ-ын үйл ажиллагаанаас, 2.8 хувь нь Хотын захирагчаас, 2.8 хувь нь Хэсгийн төлөөлөгч хэсгийн байцаагч нараас,

Он	Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн	Өмнөх онтой харьцуулсан өсөлт, бууралтын тоо	Өмнөх онтой харьцуулсан өсөлт, бууралтын хувь	Нийт хэрэгт эзлэх хувь
2017	1286	-163	-11.2	4.0
2018	1070	-216	-16.8	3.0
2019	985	-85	-7.9	6.4
2020	1138	+153	+15.5	4.8
2021	1531	+393	+34.5	6.0
2022	1567	+162	+12.9	4.8
Нийт	7577	-	-	-

11.1 хувь нь Хамтарсан багийн гишүүдээс, 11.1 хувь нь Хохирогчоос 50 хувь нь Иргэн бүрээс, 5.6 хувь нь Хууль зүй дотоод хэргийн яамнаас, 5.6 хувь нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн үйл ажиллагаас хамаарна гэж хариулсан байна.

Зураг 7. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход хамгийн түрүүнд хэнээс хамаарах вэ?



Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчийн аюулгүй байдлыг хангахад та туслахад бэлэн байна уу гэсэн асуулгад нийт судалгаанд оролцогч нарын 91.7 хувь нь

туслахад бэлэн байна гэж хариулсан бол 8.3 хувь нь туслалцаа үзүүлэх боломжгүй талаараа хариулсан байна.


Хүснэгт 1. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн статистик мэдээлэл ба судалгааны үр дүнгийн харьцуулалт



Монгол улсад гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралт, хөдөлгөөнийг 2017 оноос 2022 он хүртлэх 5 жилийн хугацаанд авч үзэхэд тогтмол өсөлт ажиглагдаж байгаа бол Улаанбаатар хотод оршин сууж байгаа иргэдээс “Монгол улсад цаашид гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн талаарх төсөөлөл” ямар байгаа талаар асуусан асуулгад нийт оролцогч нарын 25 хувь нь өснө, 13.9 хувь нь ихээр өснө гэж хариулсан байна.

Статистик үзүүлэлт болон судалгааны үр дүнг харьцуулан үзэхэд хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргийн гаралт хөдөлгөөний өсөлт болон энэ төрлийн гэмт хэргийн талаарх иргэдийн төсөөлөл адилхан байгаа байдлаас харахад цаашид энэ

гэмт хэрэг өсөх хандлага ажиглагдаж байна.



Судалгаанд оролцогч нар “Хохирогч болсон таны ойр дотны хүмүүс цагдаагийн байгууллагад энэ талаараа мэдэгдсэн үү?” гэсэн асуулгад 64.7 хувь нь цагдаагийн байгууллагад мэдэгдээгүй, 35.3 хувь нь мэдэгдсэн гэж хариулсан үр дүнг ЦЕГ-ын албан ёсны статистик мэдээлэлд бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийлэлийн улмаас хохирсон хүүхэд, эмэгтэйчүүдийн талаарх тоон үзүүлэлтийг санал асуулгын үр дүнтэй харьцуулан үзэхэд статистик мэдээний өсөлт энэ гэмт хэргийн хохирогч болсон иргэд цагдаагийн байгууллагад хандаж байгаа сайн тал харагдаж байгаа ч бодит байдал дээр цагдаагийн байгууллагад энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон 10 хүн тутам 3 нь хандаж байгаа үр дүн ажиглагдаж байна.

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явлаас урьдчилан сэргийлэх

чиглэлээр 2017-2022 онуудад дараах ажил арга хэмжээг явуулсан байна. Үүнд:

2017 онд “Айдасгүй амьдрал, амар амгалангийн элч нь цагдаа ба аав”, “Гэр бүлдээ хайртай хүн бүхэн уншаарай”, “Хаалганы цаана үйлдэгдэх хүчирхийллийн эсрэг цагдаагаас өөр хэн тэмцэж байна вэ”,

Он	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирсон эмэгтэй хүний тоо	Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэгт хохирсон хүүхдийн тоо
2017	1039	-
2018	738	51
2019	803	62
2020	964	91
2021	1310	159
2022	1468	177
Нийт	6322	540

2018 онд “Сэргийлэгч хүү, Зөвлөгч охин” “Өсвөрийн сэргийлэгч”,

2019 онд “Зөв тусгал” “Гэр бүлийн үнэ цэнэ”,

2020 онд “Сүүдэр бүү тусга” “Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Эерэг аргаар

хүмүүжүүлэх”, “Хүүхдийг зодож шийтгэх нь шийдэлд хүрэх арга зам биш”,

2021 онд “Би ... байна” “Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” “Хүүхэд хамгаалал” “Нуугдмал” “Хүүхдийн эрх, бэлгийн халдашгүй эрх чөлөө”,

2022 онд “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд туслалцаа үзүүлэх нь” “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” “Хүүхэд таныг хамгаалъя”, “Нэгдүгээрт хүүхэд” зэрэг арга хэмжээ, сургалт, зөвлөгөөн аянгуудыг тус тус зохион байгуулсан байна¹.

2017 оноос 2022 он хүртлэх хугацаанд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил арга хэмжээнүүдийн судлан үзэхэд, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, сошиал орчинг ашиглан нийтэд сэрэмжлүүлэх, анхааруулах хэлбэрээр, мөн иргэдэд мэдлэг мэдээлэл олгох танин мэдэхүйн шинжтэй сургалтыг зохион байгуулах, энэ төрлийн гэмт хэргийн талаар аян, уриалгыг олон нийтийн сүлжээгээр тараах зэрэг урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ажлыг тогтмол зохион байгуулсан боловч яагаад гэмт хэргийн гаралт буурахгүй байна вэ гэсэн асуулт урган гарч ирж байна.

Дүгнэлт

Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт явлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулсан урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээнүүдийг

нэг бүрчлэн судлан дараах дүгнэлтийг хийв.

Гэр бүлийн хүчирхийлэлд хүүхэд эмэгтэйчүүд яагаад хохирогч болж байгаа талаар урьдчилсан шалтгаан нөхцлийг тодорхойлохгүйгээр судалгаагүй арга хэмжээ зохион байгуулсан нь үр дүнд хүрэхгүй байна.

1. Судалгаагаар урьдчилсан сэргийлэх арга хэмжээнүүдийг зорилтод бүлэг рүү бус нийтэд хандсан уриа лоозон, анхааруулах, сургалт байдлаар хийсэн нь үр дүнгүй болсон.

2. Судалгаагаар 35-50 насны согтууруулах ундааны тогтмол хэрэглээтэй эрхэлсэн ажилгүй, эсвэл улиралын чанартай ажил, ростероор ажилладаг эрэгтэйчүүд хамгийн ихээр гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч байх тул нийтлэг байдлаар зохион байгуулсан соён гэрээрүүлэх нөлөөллийн арга хэмжээнүүд нь үр дүнгүй болсон.

3. Гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүд нь чанарт бус тоон үзүүлэлтэнд үндэслэсэн, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй төрийн байгууллага, алба хаагч нарын ажлын үр дүнг чанарт бус тоон үзүүлэлтээр үнэлж байгаа байдал нь сөргөөр нөлөөлж байна.

Эх сурвалжийн жагсаалт -Монгол Улсын Үндсэн хууль.

“Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 1992. №01

¹ Цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй

тэмцэх хэлтсийн 2017-2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

-Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=12694>

-Монгол улсын Эрүүгийн хууль.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=11634>

-Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийллийн криминологи, виктимологийн судалгааны тайлан 2023 он

-Цагдаагийн ерөнхий газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн 2017-2022 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлан

-НҮБ-ын Хүн амын сан, Монгол Улс дахь жендерт суурилсан хүчирхийллийн талаарх үндэсний судалгаа (Улаанбаатар: НҮБ-ын Хүн амын сан болон Үндэсний статистикийн хороо), 2018, 41 дэх тал.